

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны .... сарын ... -ны өдөр

## МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсгийг нэмсүгэй:

3 дугаар зүйлийн 3.1.2 дахь хэсэг:

“3.1.2.”Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Үндэсний ажиллагаа” гэж.

14 дүгээр зүйл:

14 дүгээр зүйл. “... болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн” гэж;

14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг:

“14.1.”...болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн” гэж;

“14.2.”...болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн” гэж.

31 дүгээр зүйл:

31 дүгээр зүйл: “...сэргийлэх” гэсний дараа “үндэсний” гэж.

“31.3.”...сэргийлэх” гэсний дараа “үндэсний” гэж, мөн зүйлийн “...төсөв нь” гэсний дараа “улсын төсвөөс санхүүжих бөгөөд” гэж, мөн зүйлийн “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны Төсвийн ерөнхийлөн захирагч байна.” гэж;

“31.3.1 Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн жилийн төсвийн төслийг төлөвлөн Улсын Их Хурлын даргад хүргүүлэх бөгөөд төслийг Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлнэ. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Байнгын хороогоор зөвшөөрөгдсөн төсвийн төслийг улсын нэгдсэн төсвийн төсөлд нэгтгүүлэхээр төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хуульд заасан хугацаанд хүргүүлнэ.” гэж;

“31.4.”...хэвлэн нийтэлнэ.” гэсний дараа “...Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, тайлангаар өгсөн санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар Улсын Их Хурал тогтоол гаргана.” гэж;

“31.5.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, түүний ажлын алба хууль тогтоомжид заасан журмын дагуу тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.” гэж;

**33 дугаар зүйл:**

“33.1.5.энэ хуулийн 33.1.8-аас 33.1.10-д заасан асуудлаар гомдол, мэдээлэл хүлээн авах, хууль зүйн зөвлөгөө өгөх” гэж;

“33.1.6.хүүхдийн эсрэг бие махбодын шийтгэл, гэр бүлийн хүчирхийллийн асуудлаар хяналт-шалгалт хийх” гэж;

“33.1.7.энэ хуулийн 33.1.6-д заасан асуудлаар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний удирдамж, чиглэлийн дагуу хүний эрхийн хяналт шалгалт явуулах” гэж;

“33.1.8.бие махбодын шийтгэл, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн эмзэг байдлын талаар цагдаагийн болон бусад хууль сахиулах байгууллагын ажилтнууд, нийгмийн ажилтан, шүүгч, прокурор, эмнэлгийн ажилтнуудад сургалт явуулах” гэж;

“33.1.9.бие махбодын шийтгэлийн хор хөнөөлийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх, хүчирхийлэлгүй арга барилыг сурталчлах, боловсрол олгох, хүүхдүүдийг өсгөх, асран халамжлахад чиглэсэн мэдлэгийг дээшлүүлэх” гэж.

“33.1.10.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих” гэж;

**Тайлбар:** гэсэн хэсэгт “...зэвсэгт хүчин, хилийн болон дотоодын цэргийн анги” гэж.

**35 дугаар зүйл:**

**35 дугаар зүйл.”...зөвлөмж” гэсний дараа “шаардлага” гэж;**

“35.5.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд хүүхдийн эсрэг бие махбодын шийтгэл,

гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн эмзэг байдлыг зөрчсөн гэж үзвэл зөрчлийг арилгуулахаар шаардлага хүргүүлнэ.” гэж.

#### 36 дугаар зүйл:

“36.1.”...гишүүнд” гэсний дараа “бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх” гэж, мөн зүйлийн “орон тооны” гэсний дараа “Ажлын алба” гэж;

“36.2.”...сэргийлэх” гэсний дараа “ажлын албаны” гэж, мөн зүйлийн “...албан хаагч байна.” гэсний дараа “Шаардлагатай тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу төрийн үйлчилгээний ажилтан, гэрээт ажилтныг ажиллуулж болно.” гэж;

“36.3.”...сэргийлэх” гэсний дараа “ажлын алба” гэж;

“36.4.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажлын алба нь тогтолцооны хяналт шинжилгээ хийх, урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны чиг үүргийг дагнан хэрэгжүүлэх бүтцээр ажиллана.” гэж;

“36.5.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгжийг чиг үүргээ бие даан хэрэгжүүлэх боломжоор хангаж, албан хаагчдын халдашгүй байдал, аюулгүй байдлыг хангана.” гэж.

#### 39 дүгээр зүйл:

“39.1.”...албан өрөө” гэсний дараа “тээврийн хэрэгсэл” гэж.

#### 40 дүгээр зүйл:

“40.4.Хуулиар бусад баталгааг тогтоож болно.” гэж тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн”...Комиссоос” гэснийг “Комисс, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээс” гэж, тус хуулийн 36 дугаар зүйлийн “...нэгж” гэснийг “Ажлын алба” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “...эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагааг хэрэгжүүлэх” гэснийг; тус хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.10 дахь заалтын “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.” гэснийг; тус хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсгийн “туслах” болон “нэгж” гэснийг; мөн зүйлийн 36.2 дахь хэсгийн “нэгжийн” гэснийг; мөн зүйлийн 36.3 дахь хэсгийн “...нэгж нь Комиссын Тамгын газарт харьяалагдах ба” гэснийг тус тус хассугай.

**4 дүгээр зүйл.** Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийг хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ